

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго

Нийслэлийн Дотоод аудитын албаны албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэн мэргэшүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулах, давтан сургалтыг зохион байгуулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

Нэг: Нийтлэг үндэслэл

Төрийн албанд оюунлаг, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгараад байгаа өнөө үед дотоод аудитын албаны албан хаагчдын боловсролыг дээшлүүлэх асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Дотоод аудитор, шинжээчид нь төрийн жинхэнэ албан хаагч, төрийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан болохын хувьд үйл ажиллагаандаа хуулийг дээдлэн мөрдөж, үлгэр жишээ ёс зүйтэй, харилцааны өндөр соёлтой, мэргэжлийн өндөр ур чадвартай, ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.2.4 заалтыг үндэслэн нийслэлийн Дотоод аудитын албаны албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсрууллаа.

Хоёр: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн Дотоод аудитын албаны даргын дэргэд эрдэмтэн, судлаачдын зөвлөл байгуулан ажиллаж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох болон үйл ажиллагааг нь зохицуулсан журмыг нийслэлийн Дотоод аудитын албаны даргын тушаалаар батална.

2.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, жил бүр хэрэгжилтийн явцыг гаргаж тайлагнах үүргийг Захиргаа, хуулийн хэлтэс, Чанарын хяналтын хэлтэс хамтран хэрэгжүүлнэ.

2.3 Дотоод аудитын албаны үйл ажиллагааны онцлог болон эзэмшсэн мэргэжлээс хамаарч гадаад дотоодын сургалтад хамрагдсан мэдлэг, чадвар, туршлага сайтай албан хаагчдаас сонгон шалгаруулж даргын тушаалаар сургагч-багшаар томилон ажиллуулж болно.

2.4 Байгууллагын удирдлага нь албан хаагчийг сургах, давтан сургах, хөгжүүлэх, чадавхийг нь бэхжүүлэх нөхцөлөөр ханган дэмжлэг үзүүлэх, албан хаагч нь өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулахад хамтран ажиллах үүргийг тус тус гүйцэтгэнэ.

2.5 Жил бүр сургалтын төлөвлөгөө гаргаж, байгууллагын даргаар батлуулан ажиллана.

Гурав: Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим, чиглэл

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчим, чиглэлийг баримтлана.

- Захирах, захирагдах ёс
- Ил тод байх
- Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх
- Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах
- Хууль дээдлэх

3.2 Сургагч-багшийн чадавхийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах

3.3. Ижил төрлийн төрийн байгууллага болон гадаад орнуудын дотоод аудитын байгууллагын сургалтын хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа сургалтын туршлагыг судлах, энэ чиглэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх

3.4 Орчин үеийн мэдээлэл, технологийн эрин зуунд дотоод аудитын байгууллагын албан хаагчид мэдлэг боловсролоо дээшлүүлэх арга замыг нээлтэй байлгаж, шинийг эрэлхийлсэн өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй албан хаагч байх сэтгэлгээг бий болгох

3.5 Сургалт, судалгааны цогц мэдээллийн баазтай болох

- Сургалтын материаллаг бааз, шаардлагатай техник тоног төхөөрөмжтэй болох
- Сургалт, судалгааны материал, гарын авлага, ном товхимол, дотоод аудитын холбогдох хууль, эрх зүйн акт, мэргэжлийн үг хэллэгийг тайлбарласан толь бичиг зэргээр баяжуулсан бичил номын сантай болох /электрон хэлбэрээр байж болно./

- Сургагч-багшийн чадавхийг дээшлүүлэх, заах арга зүйг сайжруулах чиглэлээр:

- Мэргэшлийн сургалтад хамрагдагсадыг “Сургагч-багш”-аар бэлтгэх ажлыг зохион байгуулах
- Сургагч-багшийг гадаад, дотоодын сургалт болон судалгааны ажилд өргөн оролцуулах, дадлага туршлагатай багш нарын туршлагаас суралцах бололцоогоор хангах замаар мэргэжил мэдлэгийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах
- Гадаад, дотоодын эрдэмтэн багш нарын бүтээлийг сургалт, судалгаандаа ашиглаж, дотоод аудитын албанд сургалтын материал бэлтгэх

- Сургалтыг уламжлалт лекцлэх сургалтаас асуудал дэвшүүлэх, харилцан ярилцах сургалт руу чиглүүлж, үүнтэй холбоотойгоор суралцагсдыг гарын авлага материалаар хангах

-Дотоод аудитын албаны албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:

- Байгууллагын албан хаагчдын тасралтгүй болон зайн сургалтуудыг явуулж, тэдний мэдлэг мэргэшил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулах

- Албан хаагчдыг мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамруулж, мэргэшүүлэх

- Албан хаагч өөрийн хүсэлтээр суралцах үед хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх

- Дотоод аудитор, шинжээчдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор заавал мэдэж байх ёстой хууль, эрх зүйн актын жагсаалт, эмхэтгэлтэй болж, албан хэрэгцээнд ашиглах

- Нягтлан бодох бүртгэл, дотоод аудит, хууль эрх зүй, мэргэжлийн гадаад хэлний зохих мэдлэгийг албан хаагчдад эзэмшүүлэх

- Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүж, аудит хийлгэж буй байгууллагын ажилтан, албан хаагчдад дотоод аудитын холбогдох хууль, эрх зүйн актыг зөв тайлбарлаж, зөвлөгөө өгөх чадвартай болгох

- Дотоод аудиттай холбоотой гарсан хууль дүрэм, тогтоол шийдвэр хэрхэн мэдэж байгааг бататгах зорилгоор албан хаагчдын дунд ажил мэргэжлийн мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулах

- Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах

- Дотоод аудитын албаны албан хаагчдад төрийн захиргааны албан хаагчдын болон мэргэжлийн ёс зүйгээ баримталж, авилгаас ангид байх сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх

-Судалгааны ажлын чиглэлээр:

- Дотоод аудит, төрийн аудитын чиглэлээр эрдэмтэн, судлаачдын бүтээлүүдийг нэгтгэн багцалж, танин мэдэхүйн ач холбогдолтой эрдэм шинжилгээний бичиг баримт бүрдүүлэх

- Судалгааны ажлын үр дүнг гарган бодлогын зөвлөмж боловсруулж, удирдлагуудад хүргэх

- Албан хаагч болон сургагч-багшийг судалгааны ажилд өргөн оролцуулж хэвших

Дөрөв: Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- 1 Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 2 Олон улсын байгууллага, хамтран ажилладаг орны тусламж, хандив
- 3 Бусад эх үүсвэр

Тав: Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үр дүн

5.1 Хугацаа: Сургалтын хөтөлбөрийг 2015-2016 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд жилд 1 удаа үр дүнгийн үнэлгээ хийж, шаардлагатай бол хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.2 Үр дүн:

5.2.1 Сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн орчин үеийн сургалтын бааз, техник, технологитой болж, сургалтын орчин бүрдүүлэхэд өөрчлөлт гарсан байх

5.2.2 Сургалт явуулсаны үр дүнд аудитор, шинжээчдийн хууль, эрх зүй болон дотоод аудит, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг дээшилж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас дотоод аудитын албаны үйл ажиллагаанд өгдөг үнэлгээ, нэр хүнд сайжирч, хамтын ажиллагаа сайжирсан байх

5.2.4 Ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан албан хаагч бэлтгэгдсэн байна.

Зургаа: Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтэд дараах үзүүлэлтийг үндэслэн хяналт шинжилгээ хийнэ.

А/ Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байдлын судалгаа

Б/ Дотоод аудитын нэр хүнд болон аудитор, шинжээчдийг үнэлэх үнэлэмж нэмэгдсэн байдлыг үзүүлсэн судалгаа

В/ Сургалтад хамрагдсагдын судалгаа Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Чанарын хяналтын хэлтэс, Захиргаа хуулийн хэлтэс хамтран гүйцэтгэнэ.